

Улс төрийн намуудад олгож буй төрийн санхүүжилт: Монгол улсын жишээн дээр

*Б.Эрдэнэдалай
СЭЗИС-ийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн ахлах багш,
Доктор*

Удиртгал

Орчин үед улс төрийн намын санхүүжилт улс орны хөгжилд улам бүр нөлөөтэй болж, улс төрчид, улс төрийн намуудын хувьд амжилт олох үндсэн нөхцлийн нэг болж байна. Иймээс олон улс оронд улс төрийн намын санхүүжилтийг хянах асуудлыг хуулиар зохицуулсан байдаг нь санхүүжилт олох ба зарцуулах процесс дахь улс төрийн авлигыг зогсоох, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Мөн улс төрийн намыг төрөөс санхүүжүүлснээр улс төр дэх тэгш боломж, өрсөлдөөн, шударга ёсыг хангана¹. Нам болгон санхүүгийн хувьд харилцан адилгүй байр суурьтай байдаг. Ийм нөхцөлд улс төрийн намуудын үйл ажиллагааг төрөөс санхүүжүүлэх нь намуудын том, жижгийн ялгааг улс төрийн тодорхой үйл ажиллагааны (цуглаан, уулзалт, сурталчилгаа г.м.) хувьд багасгах, улмаар хоорондоо тэгш өрсөлдөх боломжийг бүрдүүлж өгөх эерэг нөлөөтэй юм. Энэ асуудал нь шинээр ардчилалд шилжсэн, тэр дундаа пост-коммунист улсуудын улс төрийн намуудад илүү хамаатай болж байна. Учир нь ардчилал ялснаар хүлээн зөвшөөрөгдөх болсон шинээр байгуулагдсан улс төрийн намуудын хувьд хуучин коммунист намыг залгамжлан гарч ирсэн материаллаг болон санхүүгийн нөөц ихтэй намуудтай өрсөлдөхөд төрийн санхүүжилт маш чухал нөхцөл болж байгаа ажээ.

Төрөөс улс төрийн санхүүжилт хийх өөр нэгэн шалтгаан бол улс төрийн нам, нэр дэвшигчдэд янз бүрийн эх үүсвэрээс ирсэн хандивын мөнгө нь намууд болон сонгогдсон албан тушаалтнуудын улс төрийн шийдвэрт нөлөөлөх эрсдлийг багасгах учир холбогдолтой² юм. Энэ үүднээсээ төрийн санхүүжилт нь хувийн санхүүжилтийн нөлөөг бууруулахаас гадна хяналттай, хязгаартай, зохицуулалттай байдгаараа улс төрийн авлигыг хязгаарлах, хориглох чухал нөхцөл болдог байна.

Улс төр, мөнгөний хэт хамаарлыг багасгах, тэдгээрийг тусгаарлах улс төрийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтыг дэлхийн улс орнуудад чухалчилсаар ирсэн нь эндээс харагдаж байна. Монголын хувьд ч улс төрийн намын санхүүжилтийг хуулиар нарийн зохицуулж, хэрэгжүүлснээрээ улс төрөөс хамааралтай болсон улс орны эдийн засагт гарч буй зарим сөрөг үр дагаврууд зохистой шийдэгдэх боломж бүрдэнэ. Тухайлбал, эдийн засгийн үр ашиггүй байдал, төсвийн алдагдал, тооцоо төлөвлөгөөгүй зарцуулалтыг багасгах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурал, ажилгүйдлийг нааштай шийдвэрлэхэд тодорхой нөлөө үзүүлэх боломжтой болно. Мөн ардчиллыг бэхжүүлэх, намуудын дотоод ардчиллыг бий болгох, зохион байгуулалтын оновчтой бүтэц бүрдүүлэх, үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй, ил тод явуулдаг, сонгогчдын төлөө ажилладаг намыг төлөвшүүлэхэд эерэгээр нөлөөлнө.

Эдүгээ Монголын улс төрийн намуудын санхүүжилтийг Улс төрийн намын тухай болон Сонгуулийн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжууд, намын дүрэм, санхүүжилтийн журмуудаар зохицуулж байгаа билээ.

Монголын улс төрийн намуудын санхүүжилтийн үндсэн эх үүсвэр нь гишүүдийн татвар, хандив, төрийн санхүүжилтээс бүрддэг. Хандив нь улс төрийн намын орлогын чухал эх үүсвэрийн нэг юм. Төрийн санхүүжилт нь сонгуулийн амжилт, эсвэл парламент дахь суудлын тооноос хамаардаг бол хандив нь тухайн намын гадаад эх үүсвэрээс санхүүжилт олох чадвараас хамаарна.

¹ Ingrid van Biezen. 2003. Financing political parties and election campaigns-guidelines. Germany. p 14-15

² Transparency International. 2012. Anti-corruption helpdesk. Political party accountability: intra-party democracy, funding and minimum standards for candidates. p 5

Улс төрийн намд төрийн санхүүжилт олгож буй олон улсын туршлага

Өрнөдийн олон оронд төрийн санхүүжилтийн гол хэлбэр нь татаас байдаг. Ялангуяа Европын орнуудад хууль тогтоох байгууллагаас баталж намуудад мөнгөн дэмжлэг өгдөг. Төрөөс үзүүлэх дэмжлэг зөвхөн мөнгөн тусламж, татаасаар зогсохгүй, татварын урамшуулал, хөнгөлөлт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэгүй нэвтрүүлэх эрх, тодорхой бодлогын судалгаа, сонгуулийн сурталчилгаа гэх зэрэгт өгөх тэтгэлэг гэх мэт олон хэлбэрээр хэрэгжүүлж болох ажээ³. Тухайлбал, Баруун Европын ихэнх орнууд буюу Германд 1959, Шведэд 1965, Италид 1974, Испанид 1978, Францад 1988 оноос төрөөс улс төрийн намд шууд санхүүжилт үзүүлдэг хэлбэр нэвтэрсэн ба энэхүү хандлага нь шинээр ардчилсан Төв болон Зүүн Европын орнууд, Латин америкийн болон бусад бүс нутгийн орнуудад өргөн дэлгэр тархаж байна.

Улс төрийн шинжлэх ухааны олон улсын холбооны Судалгааны хорооноос эрхлэн гаргасан “Улс төрийн санхүүжилт, харьцуулсан судалгаа 1980-аад онд”⁴ бүтээлд дурдсанаар, тухайн үед төрийн санхүүжилтийг олгодог 21 улс байсан болох нь харагдаж байна.

Хүснэгт 1. Төрийн санхүүжилт олгодог улсууд 1988 оны байдлаар⁵

Улс	Төрийн санхүүжилт олгож эхэлсэн он	Улс	Төрийн санхүүжилт олгож эхэлсэн он
Аргентин	1955	Япон	1976
Австрали	1984	Мексик	1978
Австри	1963	Нидерланд	1972
Бразил	1971	Норвеги	1970
Канад	1974	Испани	1977
Коста Рика	1954	Швед	1966
Герман	1969	Турк	1983
Финлянд	1967	АНУ	1976
Франц	1965	Венесуэл	1978
Израиль	1969	Баруун Герман	1959
Итали	1974		

Улс төрийн шинжлэх ухааны олон улсын холбооны Судалгааны хорооноос хийсэн судалгаанд 1988 оны байдлаар төрийн санхүүжилтийг улс төрийн намуудад олгодог 21 улс байсан бол, Ардчилал, Сонгуулийн Туслалцааны Олон Улсын Хүрээлэнгээс 2003 онд гаргасан судалгааны гарын авлагад тухайн судалгаанд хамрагдсан 111 орны ихэнхид нь буюу 65 улсад төрийн санхүүжилт, дэмжлэг ямар нэгэн байдлаар хэрэгжиж байгаа нь улс орнууд улс төрийг төрөөс санхүүжүүлэх хандлагатай болж байгааг харуулж байна. Ингэхдээ төрөөс олгож байгаа санхүүгийн дэмжлэг ил тод байх, санхүүжилтийн үйл явцыг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд олон нийтийн хяналттай байх нь чухал юм.

Ардчилал, Сонгуулийн Туслалцааны Олон Улсын Хүрээлэнгээс хийсэн судалгаанд хамрагдсан 111 орны ихэнхид нь төрийн санхүүжилт, дэмжлэг ямар нэгэн байдлаар хэрэгжиж байгааг Хүснэгт 2-оос харж болно.

Хүснэгт 2. Улс орнууд дахь төрийн санхүүжилт ба дэмжлэг⁶

³ Austin, R. and Tjernstrom. 2003. The International IDEA Handbook series: Funding of Political Parties and Election Campaigns. Sweden

⁴ International Political Science Association. Ed. Herbert E. Alexander, Joel Federman. 1989. Comparative Political Finance in the 1980s. New York

⁵ International Political Science Association. Ed. Herbert E. Alexander, Joel Federman. 1989. Comparative Political Finance in the 1980s. New York. p14

⁶ Austin, R. and Tjernstrom. 2003. The International IDEA Handbook series: Funding of Political Parties and Election Campaigns. Sweden. p.205-208

Төрийн шууд санхүүжилт авдаг	Санхүүжилтийн үе			Дэмжлэгийн зорилго		
	Сонгуулийн үед болон Сонгуулийн хооронд	Зөвхөн сонгуулийн үед	Сонгуулийн хооронд	Сонгуулийн кампанийн сурталчилгаанд зориулдаг	Намын ерөнхий захиргаа, үйл ажиллагааны зардалд	Тодорхой зориулалтгүй
Албани Андорро Аргентин Австрали Австри Азербайжан Бельги Бенин Боливи Босни-Герцеговин Бразиль Болгар Буркино Фасо Канад Кабо Верде Колумб Коста Рика Чех Дани Доминикан Эквадор Сальвадор Эстони Финлянд Франц Гүрж Герман Гватемал Гондурас Унгар Исланд Ирланд Израиль Итали Япон Литва Малави Мали Мексик Марокко Мозамбик Намиби Нидерланд Нигер Норвеги Панам Парагвай Польш Румын ОХУ Самао Сан Марино Сан Том ба Принцип Сейшелийн арлууд Словак Өмнөд Африкийн БНУ Испани Швед Швейцар Танзани Тайланд Их Британи Уругвай	Албани Андорро Аргентин Австрали Австри Бельги Бенин Боливи Босни-Герцеговин Болгар Буркино Фасо Доминикан Эквадор Эстони Франц Герман Гватемал Унгар Исланд Израиль Итали Япон Мексик Мозамбик Намиби Нидерланд Нигер Норвеги Панам Парагвай Польш Румын Сан Марино Сейшелийн арлууд Өмнөд Африкийн БНУ Испани Швед Тайланд Их Британи	Андорро Азербайжан Канад Колумб Коста Рика Сальвадор Гондурас Малави Мали Марокко Никарагуа ОХУ Словак Танзани Уругвай	Кабо Верде Чех Дани Финлянд Ирланд Литва Португал Самао Швейцар	Албани Андорро Аргентин Австри Азербайжан Бенин Боливи Бразиль Болгар Буркино Фасо Канад Кабо Верде Колумб Коста Рика Чех Дани Эквадор Сальвадор Франц Гватемал Ирланд Израиль Коста Рика Чех Дани Эквадор Сальвадор Франц Гватемал Гондурас Израиль Итали Литва Малави Мали Мексик Марокко Мозамбик Намиби Никарагуа Нигер Панам Парагвай Польш Португал Румын ОХУ Сан Марино Сейшелийн арлууд Өмнөд Африкийн БНУ Испани Танзани Тайланд Уругвай	Аргентин Австри Бразиль Болгар Канад Колумб Дани Эквадор Финлянд Франц Гватемал Ирланд Израиль Литва Мексик Намиби Норвеги Панам Парагвай Польш Португал Румын Сан Марино Сейшелийн арлууд Өмнөд Африкийн БНУ Испани Их Британи	Албани Австрали Бельги Боливи Босни-Герцеговин Буркино Фасо Чех Дани Доминикан Эстони Финлянд Герман Исланд Израиль Итали Япон Унгар Исланд Ирланд Израиль Литва Мексик Марокко Мозамбик Намиби Норвеги Панам Парагвай Польш Румын Словак Швед Тайланд Их Британи Уругвай

Дээрх хүснэгтээс харахад:

- Улс төрийн намууддаа төрийн шууд санхүүжилт өгдөг улс 65 (59%) байна.

- Уг санхүүжилтийг 38 улсад (58%) сонгуулийн болон сонгуулийн бус үед авдаг байхад 15 улсад сонгуулийн үед, 9 улсад зөвхөн сонгуулийн бус үед авдаг гэжээ.
- Харин дэмжлэгийн зорилгын хувьд 45 улсад сонгуулийн кампанид зориулдаг бол 29 улсад нь намын ерөнхий захиргаа, үйл ажиллагааны зардалд, харин 19 улсад тодорхой зориулалтгүй олгодог аж.

Тодорхой зориулалтыг заримдаа заах боловч ихэвчлэн намын зорилго, үндсэн үйл ажиллагаанд зориулсан шинжтэй байх нь олон тохиолддог. Ийнхүү шууд санхүүжилт хийх гол шалгуур нь парламентад эзлэх суудал болон сонгуульд авсан саналын хувь хэмжээг харгалзах нь хамгийн түгээмэл байна. Мэдээжээр суудлын тоо, авсан саналын хувь хэмжээ улс бүрт, заримдаа нэг улсын санхүүжилт бүрт ялгаатай тогтоогддог болохыг Хүснэгт 3-аас харна уу.

Хүснэгт 3. Төрийн санхүүжилт олгох нийтлэг үндэслэл⁷

Намуудад ижил хуваарилдаг	Тухайн сонгуульд авсан саналд үндэслэдэг	Өмнөх сонгуулийн дүнд үндэслэдэг	Одоогийн парламентад байгаа намын суудлын тоог харгалздаг	Тухайн үеийн сонгуульд дэвшүүлсэн нэр дэвшигчийн тоог харгалздаг
Аргентин Азербайжан Бельги Босни-Герцеговин Колумб Мексик Панам ОХУ Сан Марино Өмнөд Африкийн БНУ Танзани Тайланд	Албани Андорро Австрали Доминикан Канад Коста Рика Чех Сальвадор Франц Итали Япон Марокко Никарагуа Польш Португал Словак Испани Танзани Уругвай	Албани Аргентин Боливи Бразиль Буркино Фасо Колумб Дани Эквадор Эстони Гүрж Герман Гватемал Гондурас Унгар Исланд Ирланд Литва Мексик Намиби Норвеги Панам Парагвай Польш Румын Швед	Албани Австри Бельги Бенин Босни-Герцеговин Болгар Буркино Фасо Колумб Чех Финлянд Унгар Израил Япон Мозамбик Нидерланд Нигер Норвеги Португал Румын Сан Марино Сейшелийн арлууд Өмнөд Африкийн БНУ Швед Швейцар Их Британи	Канад Кабо Верде Франц Малави Марокко Мозамбик Самао Сейшелийн арлууд

Хүснэгтээс харахад, төрөөс үзүүлэх шууд санхүүжилтийг 12 оронд бүх намуудад ижил хуваарилдаг, 19 оронд тухайн сонгуульд авсан саналд үндэслэдэг, 25 оронд өмнөх сонгуулийн дүнд үндэслэдэг, 25 оронд одоогийн парламентад байгаа намын суудлын тоог харгалздаг, харин 8 оронд тухайн үеийн сонгуульд дэвшүүлсэн нэр дэвшигчийн тоо зэрэг үзүүлэлтийг голчлон харгалздаг байна. Хамгийн түгээмэл хувилбар нь тухайн нам парламент дахь суудлын тооны босготой байх ёстой бөгөөд сонгуульд авсан саналыг тодорхой томъёогоор тооцоолон санхүүжилтийг хуваарилдаг аж.

Германы Улс төрийн намын тухай хуулиар төрийн санхүүжилт нь тухайн намын гишүүнчлэлийн татвар, хандив, бусад орлогын нэг жилийн дүнгээс хэтэрч болохгүй гэж

⁷ Austin, R. and Tjernstrom. 2003. The International IDEA Handbook series: Funding of Political Parties and Election Campaigns. Sweden. p. 209-214

заасан байдаг ажээ. Европарламент болон Бундестагийн сонгуульд тухайн нам 0.5 хувиас доошгүй санал авсан, эсвэл Ландтагийн сонгуулийн 1%-иас доошгүй санал авсан бол тухайн намд өгсөн 4 сая хүртэлх санал бүрт 0.85 евро, 4 саяас илүү гарсан санал бүрт 0.70 евро авна. Үүнээс гадна гишүүнчлэлийн татвар, хандиваас олсон нэг евро бүрт 0.38 еврогийн дүйцүүлэх санхүүжилт авах бөгөөд ингэхдээ нэг хүний 3,300 еврогоос дээшгүй хандивыг тооцдог. Шууд санхүүгийн дэмжлэгээс гадна сонгуулийн кампанийн үеэр улс төрийн намуудад хэвлэл мэдээллээр үнэгүй нэвтрүүлэг цацах дэмжлэг үзүүлдэг байна. Унгарт төрийн санхүүжилтийн 25 хувийг үйл ажиллагааны зардалд нь зориулж бүх намуудад тэгш хуваарилдаг бол үлдсэн 75 хувийг парламентийн сонгуульд авсан саналын хувьд нь харгалзуулж өгдөг байна.

Европын олон оронд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийн хэлбэр түгээмэл бөгөөд парламентад суудал авсан намын гишүүн, намын бүлэгт зориулж гаргасан дэмжлэгээс үүдэлтэй хөгжсөн байна. Мөн санхүүжүүлэгч, ивээн тэтгэгчдэд үзүүлэх урамшууллын хэлбэрүүд нь төрөөс үзүүлж буй шууд бус дэмжлэг болдог. Хувь хүмүүсээс улс төрийн намд дэмжлэг болгож өгсөн хандивын хэмжээтэй тэнцүү хэмжээний татаасыг улсаас олгодог дүйцүүлсэн санхүүжилтийн хувилбар бас байдаг. Франц, Итали, Герман, Нидерланд, Португал, Норвеги, Швейцар, Чех, Австрали, Япон, Швед, Дани⁸ зэрэг оронд улс төрийн намд хандив өгөгчид татварын тодорхой хөнгөлөлт эдэлдэг, зарим оронд улс төрийн нам нь татвараас хөнгөлөгдөх нөхцлүүд ч үйлчилдэг.

Түүнчлэн мөнгөн бус хэлбэрээр дэмжлэг үзүүлэх явдал түгээмэл байдаг. Ялангуяа, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй улс орнуудад телевиз радиогоор нэвтрүүлэг цацах эрхийг үнэгүй олгох, эсвэл сонгогчдын жагсаалт гаргаж өгөх, сонгогч иргэдэд шуудангаар үнэгүй захидал илгээх, сурталчилгааны самбарыг үнэгүй ашиглах, нийтийн эзэмшлийн байр, танхимыг уулзалт, хуралд зориулан үнэгүй ашиглах зэрэг дэмжлэгийг оруулж болно.

Судалгааны ажлаас орчин үеийн улс төрийн намыг санхүүжүүлэх төрийн санхүүжилтэд үндсэн гурван систем оршиж байна гэж дүгнэж болохоор байна. Үүнд:

1. Парламентад өөрийн хүмүүсээ нэр дэвшүүлж байгаа улс төрийн намуудад мандатын тоонд нь хувь тэнцүүлэх байдлаар төрийн санхүүжилтийг хуваарилах (Болгар, Габон, Мозамбик), нэг бол мандат бүрийн тоогоор (Дани, Финлянд) тэнцүү хуваарилах.
2. Зөвхөн парламентад нэр дэвшүүлсэн улс төрийн намуудыг санхүүжүүлж байсан шиг сонгуульд санал өгсөн тоонд харгалзуулан төрийн санхүүжилтийг хуваарилах (Бельги, Испани, Кипр). 1989 оны Бельгийн намын хуулинд “дээд доод танхимд нэг мандаттай байсан ч тэдний өгөгдсөн санал бүрийн нийлбэрээр адилхан төрийн тэтгэлэг авах эрхтэй”⁹ хэмээн заажээ.
3. Улс төрийн сонгуульд оролцож байгаа бүх улс төрийн намуудад тодорхой хэмжээгээр жигд санхүүжилт олгох ба тэд хэнээс ч хамааралгүй бие даасан байх, мөн парламентад нэр дэвшүүлэх болзол зэргийг хангасан байх ёстой (Австри, Грек, Герман, Франц, Чех, Швед г.м).

Улс төрийн намд төрийн санхүүжилт олгож буй олон улсын сайн туршлага байгаа боловч намуудад төрийн санхүүжилт олгож, түүнийг зохицуулах арга хэмжээг тухайн улсын онцлог, төрийн байгууламжийн шинж чанарт тохируулж нарийвчлан оновчтой зохицуулахгүй бол дараах тооцоолоогүй үр дагавар, эрсдэлд хүргэж болдог байна. Тухайлбал:

- Намын бие даасан байдал нь төрийн санхүүжилтээс хамааралтай болсон. Энэ нь ялангуяа зонхилогч намууд эрх мэдлийг барьж байсан шилжилтийн үед гол асуудал болдог.

⁸ Ашкеров. А. Ю и другие. 2007. Основы теории политических партий. Политучеба. Москва. С.207-218

⁹ Ю.Юдин. 1998. Политические партии и право в современном государстве. Москва. С.161


- Төрийн санхүүжилтийн хувь хэмжээ нь сөрөг хүчний намуудад шударга бус байх тохиолдол үүсдэг. Парламентад төлөөлөлгүй жижиг намууд санхүүжилт авах нь асуудалтай. Тэгш өрсөлдөх нөхцөл бүрдэхгүй.
- Төрөөс улс төрийн намуудыг санхүүжүүлж байгаа явдал олон түмэнд таалагдахгүй байж болно. Төрийн мөнгийг тооцоо, үр ашиггүй зарцуулах явдал гарч болдог.
- Жижиг, шинээр төрөн гарч буй намуудад төрийн санхүүжилт очихгүй байх магадлалтай (парламент дахь суудлыг үндэслэж өгч байгаа бол).
- Төрөөс олгох санхүүжилтийг зардлын хязгаарлалттай хослуулахгүй бол том намууд болон жижиг намууд хоорондын хөрөнгө чинээ, мөнгөний ялгаа багасахгүй зэрэг сөрөг үр дагаврууд гардаг.

Иймээс улс төрийн намуудад олгож буй төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад голлон анхаарах нь чухал. Санхүүжилтийн ил тод байдлыг дараах байдлаар хангаж болох юм.

- Улс төрийн намууд санхүүгийн баримт, тайлангаа нээлттэй байлгах ёстой бөгөөд түүнд нь хандивлагчийн нэр, мөнгөний хэмжээ, зарцуулалтыг тодорхой гаргах;
- Санхүүгийн тайланг олон түмэнд болон сонгуулийн ерөнхий хороо, аудитын байгууллага зэрэг тодорхой байгууллагуудад мэдээлэх;
- Бие даасан, хараат бус, хөндлөнгийн байгууллагаар санхүүжилтэд мониторинг, хяналт шинжилгээ хийлгэх;
- Төрөөс олгох санхүүжилтийг санхүүгийн тайлангаа олон нийтэд ил тод мэдээлсэн, хуульд заасан хугацаанд ирүүлсэн нам, нэр дэвшигчдэд улирал, хагас жил тутам олгох. Хууль зөрчсөн тохиолдолд санхүүжилтийн хэмжээг бууруулах, олгохгүй байх хүртэл арга хэмжээ авдаг байх;
- Улс төрийн санхүүжилтийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг байх.

Улс төрийн санхүүжилтийг иргэд, судлаачдад ил тод, нээлттэй байлгахын тулд санхүүгийн тайланг хүлээн авдаг, хянадаг, олон нийтэд мэдээллийг нээлттэй хүргэх албан ёсны биеэ даасан бүтэц байх ёстой. Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэнгээс 2014 онд гаргасан судалгаанд дэлхийн 209 орныг хамруулж улс төрийн намууд санхүүгээ ямар институтэд тайлагнадгийг харьцуулан дүгнэсэн.

Зураг 1. Санхүүгийн тайлангаа өгдөг эсэх¹⁰?




Дээрх дүнгээс харахад, санхүүгийн тайлангаа өгдөггүй 41 улс буюу судалгаанд хамруулсан 209 улсын 22,8 хувь нь санхүүжилтийн асуудлыг ил тод, нээлттэй бус байлгах ашиг сонирхол байгааг харуулж байна.

Зураг 2. Санхүүгийн тайлангаа ямар институтэд өгдөг вэ¹¹?

¹⁰ Falguera E, Jones S, Ohman M. 2014. "Funding of Political Parties and Election Campaigns". A Handbook on Political Finance. Sweden. p. 31

¹¹ Falguera E, Jones S, Ohman M. 2014. "Funding of Political Parties and Election Campaigns". A Handbook on Political Finance. Sweden. p. 31



Тайлангаа өгдөг улсуудын хувьд, Сонгуулийн ерөнхий хороонд 61 улс, Аудитын байгууллагад 25 улс, санхүүгийн тайлан авдаг бие даасан институтэд 16 улс өгдөг байна. Ингэхдээ санхүүгийн тайланг хүлээн авч байгаа дээрх институтүүдэд эрх баригч намын төлөөлөл зонхилох ёсгүй, харин санхүүгийн тайланд аудит шалгалт хийх мэргэжлийн чадвар бүхий төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн төлөөлөл ордог байна.

Эдгээрээс гадна улс төрийн намуудад олгож буй төрийн санхүүжилтийг ил тод болгохын тулд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй болдог. Үүнд:

- Орлого болон зарлагыг хооронд нь ялган авч үзэх
- Доод хэмжээг даван гарсан хандив мэдээлэгддэг байх
- Хандив нь нэр төрлөөрөө тодорхой стандарт, ангилалд орсон байх
- Ил тод болгох явц нь улс төрийн намын санхүүжилт болон нэр дэвшигчийн санхүүжилтийг ялгаж өгөх
- Сонгуулийн үеийн болон сонгуулийн бус үеийн санхүүжилтийг тусад нь авч үзэх
- Үндэсний хэмжээний болон орон нутгийн намын байгууллагын тайланг хоёуланг нь оруулах
- Ил тод болгох явдал нь хандивлагч болон хандив авч буй нам, нэр дэвшигчийн үүрэг хариуцлагын асуудал байх
- Тайлан нь тогтмол, өргөн хүрээтэй мэдээллийг агуулсан, ард иргэдэд ойлгомжтой байх ёстой.

Монголын улс төрийн намуудад олгож буй төрийн санхүүжилт, өнөөгийн байдал

Ерөнхийдөө ихэнх хөгжингүй, ардчилсан орнууд болон ардчилсан шилжилт хийсэн орнуудад төрийн санхүүжилт нэлээд түгээмэл хэрэглэгдэж ирсэн. Манай оронд ч улс төрийн намын тухай хуульд намуудад олгох төрийн санхүүжилтийн тухай хуульчилж өгсөн. Гэтэл улс төрийн намууд, сонгогдсон гишүүд Монгол улсын хуульд заасан санхүүжилтаас гадна хоёр хэлбэрийн хууль бус санхүүжилтийг төрөөс авч байгаа нь судалгааны дүнд ажиглагдлаа. Эндээс улс төрийн намууд нийт дараах хэлбэрийн санхүүжилтуудыг авч байна.

1. Улс төрийн намын тухай хуульд зааснаар, төрөөс улс төрийн намуудад олгох санхүүжилт. (- Хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа санхүүжилт олгоно. - Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд 10 сая төгрөгөөр тооцож санхүүжилт олгоно.)
2. Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн суудлын мөнгө гэх хуульд заагаагүй санхүүжилт.
3. Улсын Их Хурлын гишүүний мөнгө гэх хуульд заагаагүй санхүүжилт.

1. 2005 оны Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлд төрөөс авах санхүүгийн дэмжлэгийг дараах 2 төрлөөр байхаар хуульчилсан. Үүнд, Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлнэ. Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд 10 сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгох бөгөөд санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгогдсон тойрогт зарцуулна гэж хуульчилсан байна. 2000-2011 оны хооронд УИХ-д суудалтай намуудын санхүүгийн дэмжлэгт нийтдээ 6.9 тэрбум төгрөг олгожээ.

УИХ-ын гишүүний нэг суудлыг Улс төрийн намын 1990 оны хуулиар нэг сая төгрөгөөр тооцож төрөөс санхүүжилт олгож байснаа 2001 оноос 2.5 сая төгрөг болгон нэмсэн нь хууль зөрчсөн үйлдэл болсныг шалгаад хуульд өөрчлөлт оруулалгүйгээр санхүүжилтийн хэмжээг ингэж өсгөсөн нь хууль бус үйлдэл гэдгийг Үндэсний Аудитын газраас тогтоосон байдаг.

2008 оны УИХ-ын сонгуулийн санал өгөлтийн дүнгээс үзвэл тухайн намын авсан хүчинтэй нэг саналыг 1000 төгрөгөөр тооцон бодож гаргавал дараах дүн гарч байна. Үүнийг УИХ-д суудал бүхий дөрвөн намаар хүснэгтэлж үзүүлбэл,

**Хүснэгт 4. Намуудын сонгуулийн үр дүнгээр төрөөс авсан санхүүжилт.
Хүчинтэй саналын тоотой харьцуулбал¹²**


№	Намын нэр	Авсан хүчинтэй саналын тоо	Санхүүжилт
1.	МАН	913032	913,032000
2.	Ардчилсан нам	728455	728,455000
3.	Ногоон нам	24806	24,806000
4.	Иргэний Зориг нам	34318	34,319000
	Нийт дүн	1700611	1,700,611000

Дээрх дөрвөн намаар жишээлэн үзэхэд нэг саналын дэмжлэг тухайн намын санхүүжилтэд чухал эх үүсвэр болж байгаа нь илэрхий байна. Мөн Сангийн яамны харьяа Төрийн сангийн газрын мэдээлснээр УИХ-д суудалтай улс төрийн намуудад хуулийн дагуу олгож байгаа санхүүжилтийн хэмжээг дараах зурагт харьцуулан харууллаа.

Зураг 3. УИХ-д суудалтай намуудад 2005-2013 онуудад төрөөс олгосон санхүүгийн дэмжлэг, сая төгрөгөөр¹³ (Төрийн сангийн газар)

¹² С.Мөнхбат. 2009. Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшлийн асуудал. Докторын диссертаци. Улаанбаатар хот. Хуудас 121

¹³ Төрийн сангийн газраас албан ёсоор мэдээлсэн дүнг <https://tusuv.wordpress.com/> сайтаас авав.



Судалгааны ажилтай холбоотойгоор 2015 оны 3-р сард Сангийн яамны харьяа Төрийн сангийн газрын мэргэжилтнээс судалгаа авахад Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намууд төрөөс олгох санхүүжилтийг авч байгаа ч санхүүжилтийг ямар байдлаар зарцуулж байгаа нь тодорхойгүй байгааг дараах ярилцлагаас харж болно.

Төрийн сангийн газрын УИХ-ын төсөв хариуцсан мэргэжилтэн:

Улс төрийн намуудад олгох суудлын мөнгийг олгохдоо УИХ-д хэдэн суудал авсан гэдэг албан ёсны тоог, олгох мөнгөн дүнтэй нь УИХ-ын тамгын газраас гаргаж өгдөг. Харин намуудын авсан нийт хүчинтэй саналын тоог Сонгуулийн ерөнхий хороо гаргаж өгөхөөр санал бүрийг 1000 төгрөгөөр тооцож, дээрх баримтуудыг үндэслээд улс төрийн намуудад санхүүжилтийг олгодог. Санхүүжилт олгосны дараа улс төрийн намуудаас төрөөс олгосон санхүүжилтийг ямар байдлаар зарцуулсан, зарцуулалтад намын гишүүдийн оролцоо байсан эсэх зэрэг зардлын тайланг хүлээн авах, шалгах эрх манай байгууллагад байхгүй, шалгасан хяналт тавьсан тохиолдол ч байхгүй.

- Улс төрийн намууд өөрсөддөө төсвийн мөнгийг хууль бусаар хуваарилах, төсвөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг үндэслэлгүйгээр нэмэх, намд орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох хуулийн заалт байхгүй атал ИТХ-ын төлөөлөгчийн суудлын мөнгө гэх нэрээр 2000-2006 онд 1.8 тэрбум, 2009 онд 0,5 тэрбум төгрөг, 2014 онд 45 төлөөлөгч тус бүрдээ 12 сая төгрөгийг нийт 540 сая төгрөгийн санхүүжилт авсан.

Нийслэлийн Аудитын газрын дарга Ц.Очирбат:

Төлөөлөгч нарт олгож байгаа урамшууллыг эргээж харах шаардлагыг НИТХ-ын даргад хүргэсэн. Хэрвээ энэ байдлаараа үргэлжлүүлэн олговол нийгмийн даатгалын шимтгэл, бусад хууль тогтоомж, татварын хуулинд нийцүүлж хэрэгжүүл. Эсвэл урамшууллыг байхгүй болго. Өөр хөрөнгө оруулалтын журмаар арга замаа шийд гэсэн чиглэлийг өгсөн. 2015 оны Нийслэлийн төсөвт уг урамшуулал тусгагдахгүй байх гэж найдаж байна.

ТМ телевизийн сэтгүүлч н.Өнөрцэцэгийн бэлтгэсэн мэдээ:

Тойргоос бус, намын жагсаалтаар төлөөлөгч болж сонгогдсон хүмүүст тойрогт зарцуулагдах мөнгийг хувиарлаж байна. Зарим төлөөлөгч тойрогт зарцуулагдах мөнгийг цалин болгож ашигладаг. Гэвч төсөвт НИТХ-ын урамшуулалд 1,8 тэрбум төгрөг тусгасан байгаа.¹⁴

Нийслэлийн Аудитын газрын дарга Ц.Очирбат Нийслэлийн төсөвт төлөөлөгч нарт олгож байгаа урамшуулал тусгагдахгүй байх гэж ярилцлага өгсөн байхад ТМ телевизийн сэтгүүлчийн бэлтгэсэн мэдээнд НИТХ-ын урамшуулалд дахиад мөнгө төсөвлөсөн байгаа нь төрийн байгууллагууд аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган, цаашид тухайн асуудлыг шийдвэрлэх асуудал байхгүй болох нь харагдаж байна.

¹⁴ Мэдээллийн сайт. <http://www.hunnu.mn/content/54464.htm?fdkjgsd>

3. Улсын Их Хурлын гишүүний мөнгө (1 тэрбум төгрөг) гэх хуульд заагаагүй санхүүжилт. УИХ-аас 2007 оны Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа “орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт” нэрээр 250 сая төгрөгийг сонгуулийн тойрог бүрт хуваарилан баталсныг Үндсэн хуулийн цэцээс “УИХ-ын гишүүдийн тус тусын тойрогтоо хөрөнгө оруулахаар гаргасан санал, жагсаалтыг үндэслэн УИХ-ын сонгуулийн тойргийн журмаар тойрог тус бүрт тэгшитгэн хуваарилж, зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тараан байршуулсан 250 сая төгрөг буюу нийт дүнгээрээ төөвт туссан 19.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь¹⁵...” гээд Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж буй 6 зүйлийн 7 заалтыг жагсаан бичиж дүгнэлт гаргасан байна.

Дээрх байдлаар Үндсэн хуулийн цэцээс тойрогт хуваарилж буй УИХ-ын гишүүний гэх энэ мөнгийг Үндсэн хууль зөрчиж байгаа талаар шийдвэр гарсан, хүчин төгөлдөр үйлчлэх байтал үг үсэг төдийгөөр зүсийг өөрчлөн жил жилийн төсөвт суулгаж, өрхийн эмнэлэгт машин, сургууль цэцэрлэгт гал тогоо нийлүүлэх, тойргийнхоо сонгогчдод гэр бэлэглэж, сууцных нь дээврийг засах төдийгөөр захиран зарцуулж ирсэн¹⁶.

УИХ-ын төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэн:

УИХ-ын гишүүд 1 тэрбум төгрөгийг өөрсдийн нэр дээр авдаггүй. Гишүүд тэр мөнгийг захиран зарцуулах эрх байдаггүй. Харин өөрийн сонгогдсон тойрогтоо ямар ажил хийх шаардлагатай байгаа хэрэгцээн дээр тулгуурлаад саналаа өгдөг. Тэр саналуудыг үндэслэж төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдлийн багцад нь тухайн мөнгийг суулгаж өгдөг.

Ардчиллыг бэхжүүлэх нэг үндэс нь чөлөөт, шударга сонгууль байдаг. Чөлөөт, шударга сонгуулийн чухал үзүүлэлт бол сонгуульд өрсөлдөж буй талуудын тэгш гараа, өрсөлдөх тэгш боломж байдаг. Мөн Монгол улсын Үндсэн хуульд иргэн бүр сонгох, сонгогдох эрхтэй гэж заасан байдаг бол энэ эрхүүд Улсын Их Хурлын гишүүний тойргийн мөнгө гэх санхүүжилтийн хэлбэрээр зөрчигдөж байна. Уг нь төсвийн хөрөнгөөр хийж байгаа бүтээн байгуулалт нь сонгуульд өрсөлдөхөд ямар нэг байдлаар давуу тал бий болгох ёсгүй. Гэтэл УИХ-ын гишүүд тойргийнхоо сонгогчдод төсвийн хөрөнгөөр хийж байгаа ажил, үйлчилгээг өөрөө хийсэн болгох “жүжиг” тоглож явах болсон. Энд төсвийн хөрөнгийг сонгуулийн амлалтуудаа биелүүлэх, дараагийн сонгуулийн бэлтгэл болгож нэр хүндээ өсгөх хандлага ажиглагдаж байна.

Дүгнэлт

Судалгааны ажлын хүрээнд Монгол дахь улс төрийн намуудад олгож буй төрийн санхүүжилтийн асуудалд улс төр, эрх зүйн шинжилгээ хийж улс төрийн санхүүжилтийн асуудлыг ил тод, нээлттэй болгох, цаашид ардчиллыг бэхжүүлэхэд нөлөө үзүүлэх шийдвэрлэх арга замуудыг улс төрийн санхүүжилтийн сайн практик бүхий улс орнуудын загвартай харьцуулан дэвшүүлж, санал зөвлөмж гаргахыг зорьсон.

Судалгааны явцад Монгол дахь улс төрийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь харагдаж байна. Хуульд санхүүжилтийн хэлбэр, хяналт тавих, хариуцлага тооцох, хууль хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалтууд тусгаагүй тул намуудын хариуцлага бүхэлдээ суларч, санхүүжилтээ хууль зөрчиж босгох (ингэснээр сонгогдсон улстөрчид эргээд ард түмэнд бус өөрийг нь санхүүжүүлсэн хандивлагчдад үйлчлэх, тэдэнд зориулсан хууль батлах, нийгэм, эдийн засгийн бүтээн байгуулалттай холбоотой тендерт ялалт байгуулах), төрөөс олгосон санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулах, орлого, зарлагын мэдүүлгээ тайлагнахгүй байх зэрэг олон зөрчил, дутагдал бодитой оршоор байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд хувь хүний оролцоог нэмэгдүүлснээр тухайн улс төрийн нам, улс төрч, нэр дэвшигч, сонгогдсон парламентийн гишүүн зэрэг улс

¹⁵ Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн 2007.02.23-ны өдрийн 02 тоот дүгнэлтээс

¹⁶ С.Оюунтуяа. 2010. УИХ-ын гишүүний нэг тэрбум төгрөг. Иргэд төсвөө хянана ТББ-ын сүлжээ. Улаанбаатар хот. Хуудас 2

төрийн субъектүүдийн аль аль нь санхүү, мөнгөний хувьд нэг буюу цөөн тооны эдийн засгийн бүлгээс хараат бус байх урьдач нөхцөл болно. Өөрөөр хэлбэл, олон жижиг санхүүжүүлэгчтэй болсноор энэ байдал хангагдах юм. Харин хувь хүнээс авах санхүүжилтийн дээд хязгаарыг тогтоох шаардлагатай. Ингэснээр намууд болон нэр дэвшигчид аль болох олон хүнээс санхүүжилт олоход санхүүжилтийн болон кампанит ажлын зорилго, чиглэлээ хандуулах болно. Энэ нь нэр дэвшигчдэд улс төрийн өрсөлдөөний ижил тэгш боломж олгоно. Намуудын, эсвэл нэр дэвшигчийн хувьд зарцуулж болох сонгуулийн зардлын дээд хэмжээг төрөөс тогтоож өгөх шаардлагатай. Ингэсэн тохиолдолд ялалт байгуулсан нэр дэвшигчид нөхөн олговор олгох тогтолцоог урьдчилсан зардлын тооцоонд үндэслэн тогтоох боломжтой юм.

Бодлогын зөвлөмж

Судалгааны ажлын хүрээнд Монгол дахь улс төрийн намуудад олгож буй төрийн санхүүжилтэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дараах бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Төрөөс улс төрийн санхүүжилтийн асуудлыг зохицуулахдаа зөвхөн улс төрийн намаар хязгаарлалгүй, сонгуульд нэр дэвшин оролцож буй субъектүүдийн улс төрийн тэгш бололцоог хангах нь зүйтэй юм. Улс төрийн тэгш бололцоог хангаснаар сонгуулийн өрсөлдөөнийг ижил тэгш, тэнцвэртэй байлгах нөхцөл бүрдэнэ.
- Улс төрийн намын санхүүжилтийн эх үүсвэр, төрөл, хэмжээ зэргийг авлигаас сэргийлэх асуудалтай хослуулан зохицуулах шаардлагатай. Ингэснээр улс төрийн намаар дамждаг авлигыг хориглох нөхцөл бүрдэнэ.
- Улс төрийн санхүүжилтийг хянах иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоог төрөөс мониторинг хийх үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, мониторингийн үр дүнг олон нийт, улс төрийн намуудад мэдээлэх, нөлөөллийн үйл ажиллагаа зэргийг дэмжих хэрэгтэй байна.
- Мөн улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах үүднээс улс төрийн нам, нэр дэвшигчид санхүүгийн тайлангаа олон нийтэд нээлттэй мэдээлэх ёстой. Олон нийтэд ил тод байлгахын тулд хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн бүлгүүд, судлаачид намын санхүүгийн тайланг гаргуулан авах, уг тайланг ашиглан сонгуулийн санхүүжилтэд шинжилгээ хийх, үр дүнг нийтийн хүртээл болгох боломжийг бүрдүүлэх нь иргэний нийгмийн хөгжилд төдийгүй ардчиллын бэхжилтэд ч эерэг нөлөөлөх болно.
- Сонгуулийн ерөнхий хороонд улс төрийн намуудаас ирүүлсэн хандивын болон сонгуулийн зардлын тайлан, сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн ирүүлсэн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгч байх механизмыг хуулиар тодорхой болгох шаардлагатай юм.
- Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг уян хатан тогтоохдоо сонгуулийн кампанит ажлын цар хүрээ, зардал зэргээс хамааран хариуцлагыг ялгаатай тогтоох нь оновчтой шийдэл болно. Тухайлбал, мөнгөн торгууль, улс төрийн намыг сонгуульд оролцох эрхийг түдгэлзүүлэх, төсвөөс олгох санхүүжилтийг багасгах, цуцлах, парламентийн суудлыг хүчингүйд тооцох, улс төрийн намыг татан буулгах зэрэг хэлбэрүүдтэй байх.
- Улс төрийн намыг санхүүжүүлэхэд санхүү, бизнесийн байгууллагын оролцоог хориглох нь улс төрийн нам бизнесээс хараат болох эрсдлээс зайлсхийх ач холбогдолтой юм. Иймд улс төрийн санхүүжилтийг хуулийн этгээдээс /бизнесийн байгууллага, төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл/ авахыг аль болох хязгаарлах, улмаар хориглосноор улс төрийг мөнгөнөөс ангид авч үзэх нөхцөл бүрдэхэд чухал нөлөөтэй. Харин цаашдаа улс төрийн үйл ажиллагааг намын гишүүд, дэмжигчид болон улс төрийн идэвх санаачлагатай иргэд өөрсдөө, мөн төрөөс

хяналттай бөгөөд тэгш санхүүжүүлэх механизмыг оновчтой бүрдүүлэх шаардлагатай байна.

Төрөөс санхүүжүүлэх дараах хэлбэрүүд байж болно. Үүнд:

1. Сонгуулийн өмнө нам, нэр дэвшигчдэд өгөх татаас.

- Намд өгөх татаасын хэмжээг сонгуульд оролцохоор бүртгүүлсэн намуудад тухайн намаас нэр дэвшигчдийн тоотой уялдуулан харьцангуй ижил тогтоох.
- Нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлын зардлын тодорхой хувийг татаас хэлбэрээр олгох.
- Сонгуулийн сурталчилгааны мөнгөн бус санхүүжилт.

2. Сонгуулийн дараа намуудад өгөх нөхөн олговор.

- Сонгуулийн дүн гарсны дараа улсын төсвөөс намуудад суудлын тоогоор олгох урамшуулал.
Зарцуулалтад тодорхой чиглэл гаргаж өгөх. (Санхүүжилтийн 40-өөс доошгүй хувийг намын мөрийн хөтөлбөр, бодлого боловсруулахад, 20-иос доошгүй хувийг гишүүд дэмжигчдийн улс төрийн боловсролд, 15-аас доошгүй хувийг хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, сурталчилгаанд гэх мэт)
- Зөвхөн УИХ-д суудал авсан нам бус, сонгогчдын тодорхой хувийн санал авсан намд авсан саналыг үндэслэж олгох урамшуулал.
Босго 1-3%. (1000 төгрөгийг дотоодын нийт бүтээгдэхүүний тодорхой хувьд харгалзуулан тогтоох. 2012 оны УИХ-ын сонгуульд Гурав дахь хүчин эвсэл-1,47%, Монголын Ногоон нам-1,33%, Эх Орон нам-0,80%)
- Улсын төсвөөс шууд биш, зөвхөн Сонгуулийн ерөнхий хороонд хувь хүнээс өгсөн хандивыг нэр дэвшигчдэд сонгуулийн зардлын нөхөн олговор хэлбэрээр хуваарилах.
- Дээрх санхүүжилтүүдийг олгох цаг хугацааг оновчтой тогтоох.

Ном зүй

1. Austin, R. and Tjernstrom. 2003. The International IDEA Handbook series: Funding of Political Parties and Election Campaigns. Sweden
2. Falguera E, Jones S, Ohman M. 2014. "Funding of Political Parties and Election Campaigns". A Handbook on Political Finance. Sweden
3. Ingrid van Biezen. 2003. Financing political parties and election campaigns-guidelines. Germany
4. International Political Science Association. Ed. Herbert E. Alexander, Joel Federman. 1989. Comparative Political Finance in the 1980s. New York
5. Transparency International. 2012. Anti-corruption helpdesk. Political party accountability: intra-party democracy, funding and minimum standarts for candidates
6. Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн 2007.02.23-ны өдрийн 02 тоот дүгнэлт
7. Ж.Төртогтох, Б.Эрдэнэдалай. 2015. "Улс төрийн намыг төрөөс санхүүжүүлэх нь" бодлогын судалгаа. Нээлттэй нийгэм форум. Бодлогын асуудал цуврал №14. Улаанбаатар хот
8. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төв. 2012. "Улс төрийн санхүүжилт ба намын хөгжлийн хандлага" судалгааны тайлан. Улаанбаатар хот
9. Ашкерев. А. Ю и другие. 2007. Основы теории политических партий. Политучеба. Москва
10. Ю.Юдин. 1998. Политические партии и право в современном государстве. Москва
11. Иргэд төсвөө хянана сайт <https://tusuv.wordpress.com/>